



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 126

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.2, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын авто бааз" төрийн өмчит үйлдвэрийн газар болон "Хүмүүн фильм" нийтэд үйлчлэх төрийн бус байгууллагын хооронд 2019 онд байгуулсан "Автомашинаар үйлчлүүлэх тухай гэрээ"-ний хүрээнд үүссэн авлагыг барагдуулах зорилгоор хүлээн авсан 56,000,000.00 (тавин зургаан сая) төгрөгийн үнэлгээ бүхий Мерседес бенз ML350 маркийн, 25-56 УКУ улсын дугаартай автомашиныг "Засгийн газрын авто бааз" төрийн өмчит үйлдвэрийн газарт эзэмшүүлэн, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. "Засгийн газрын авто бааз" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. "Хүмүүн фильм" нийтэд үйлчлэх төрийн бус байгууллагаас энэ тогтоолд заасан автомашиныг холбогдох баримт материалын хамт хүлээн авах ажлыг зохион байгуулж, үндсэн хөрөнгөд бүртгэх;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд"-д бүртгэх;

2.3. Энэ шийдвэрийг "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газарт хүргүүлэн бүртгүүлж, тээврийн хэрэгслийг татвар төлөгчийн бүртгэл, улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ
132000346
7-r huraldaan.docx